

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУС	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайд
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН
ЗАХИРАЛ Д.ОТГОНСҮРЭН ТАНАА

2021.02.25 № 07/578
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойжин ламын сүм музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Чойжин ламын сүм музей нь тайлант онд 17 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	60,398,975.60	56,987,411.34
33	АВЛАГА	3,753,736.60	4,436,615.34
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	466,569.34
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	600,446.00
335	Бусад авлага	3,753,736.60	3,369,600.00
3351	Байгууллагаас авах авлага	3,753,736.60	3,369,600.00
34	УРЬДЧИЛГАА	11,600,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	11,600,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,045,239.00	52,550,796.00
354	Хангамжийн материал	45,045,239.00	52,550,796.00
35410	Бичиг хэргийн материал	18,088,955.00	11,637,748.00
35420	Аж ахуйн материал	13,520,818.00	12,758,518.00
35430	Сэлбэг хэрэгсэл	275,000.00	2,169,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,160,466.00	25,985,530.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,015,162,655.31	4,968,313,599.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,015,162,655.31	4,968,313,599.11
392	Биет хөрөнгө	4,357,562,655.31	4,310,713,599.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	301,521,218.50	291,812,104.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-554,873.52	-33,363,425.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	195,265,673.33	193,714,843.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-161,816,658.94	-165,543,863.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,743,139.00	57,441,109.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,734,374.58	-28,448,160.04
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,954,292,959.00	3,954,292,959.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,961,652.52	45,961,652.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-7,037,540.40
39217	Ном	1,883,920.00	1,883,920.00
393	Биет бус хөрөнгө	657,600,000.00	657,600,000.00
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-990,000.00	-990,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	657,600,000.00	657,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,075,561,630.91	5,025,301,010.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,802,230.19
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,802,230.19
413	Өглөг	00.00	1,802,230.19
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,802,230.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,075,561,630.91	5,023,498,780.26
51	Засгийн газрын хувь оролцоо	5,075,561,630.91	5,023,498,780.26

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,906,414,021.00	1,906,414,021.00
51101	Өмч: - төрийн	1,906,414,021.00	1,906,414,021.00
512	Хуримтлагдсан үр дүн	623,029,859.57	580,676,122.52
51210	Өмнөх үеийн үр дүн	623,029,859.57	632,738,973.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-52,062,850.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,546,117,750.34	2,536,408,636.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,075,561,630.91</u>	<u>5,025,301,010.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	906,374,673.58	370,501,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	504,898,473.58	12,403,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	504,898,473.58	12,403,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	504,898,473.58	12,403,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	504,898,473.58	12,403,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,476,200.00	358,097,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	323,223,200.00	341,456,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	323,223,200.00	341,456,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,253,000.00	16,641,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	78,253,000.00	16,641,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	571,280,856.20	410,753,632.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	571,280,856.20	410,753,632.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	567,626,342.20	408,463,531.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,807,018.00	222,699,657.60
210101	Үндсэн цалин	167,373,445.00	178,941,570.60
210102	Нэмэгдэл	30,421,673.00	30,238,376.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,011,900.00	9,979,716.00
210104	Урамшуулал	00.00	3,539,995.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,112,078.00	28,984,828.25
210201	Тэтгэврийн даатгал	17,383,501.00	19,970,444.42
210202	Тэтгэмжийн даатгал	1,432,144.00	2,349,464.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,145,715.00	1,778,771.22
210204	Ажилгүйдлийн даатгал	286,429.00	439,220.53
210205	Эрүүл мэндийн даатгал	2,864,289.00	4,446,928.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,984,176.00	17,325,890.60
210301	Гэрэл, цахилгаан	15,595,888.00	16,355,517.60
210303	Цэвэр, бохир ус	2,388,288.00	970,373.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,125,521.00	25,392,676.18
210401	Бичиг хэрэг	5,730,250.00	11,145,853.00
210402	Тээвэр, шатахуун	2,992,900.00	2,718,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	261,921.00	624,985.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	173,800.00	1,660,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,966,650.00	9,242,938.18
2105	Нормативт зардал	100,000.00	60,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	60,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	203,067,354.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,253,600.00	00.00
210602	Тавилга	20,000.00	00.00

210604	Урсгал засвар	200,793,754.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	12,351,654.00	900,000.00
210701	Гадаад албан томилолт	10,351,654.00	900,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,440,960.00	53,573,896.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,340,960.00	44,351,267.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	3,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000.00	999,400.00
210807	Газрын төлбөр	4,200,000.00	4,199,580.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	223,649.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,637,581.20	59,526,583.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,756,769.00	4,365,330.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,880,812.20	55,161,253.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,654,514.00	2,290,100.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,654,514.00	1,290,100.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,654,514.00	1,290,100.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>335,093,817.38</u>	<u>-40,252,632.75</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	11,810,217.90
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	11,810,217.90
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-11,810,217.90
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>335,093,817.38</u>	<u>-52,062,850.65</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	401,476,200.00	358,097,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,476,200.00	358,097,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	323,223,200.00	341,456,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	323,223,200.00	341,456,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,253,000.00	16,641,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	77,253,000.00	16,641,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	393,590,800.00	358,097,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,590,800.00	358,097,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,936,286.00	355,207,353.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,878,299.00	222,496,226.00
210101	Үндсэн цалин	145,499,909.00	178,784,262.00
210102	Нэмэгдэл	36,430,490.00	30,192,253.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,348,900.00	9,979,716.00
210104	Урамшуулал	10,599,000.00	3,539,995.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,950,964.00	27,852,599.00
210201	Тэтгэврийн даатгал	20,991,306.00	17,738,437.00
210202	Тэтгэмжийн даатгал	881,878.00	4,078,592.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,851,218.00	2,566,107.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,805.00	462,651.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,763,757.00	3,006,812.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,326,288.00	13,572,154.00
210301	Гэрэл, цахилгаан	11,938,000.00	12,601,781.00
210303	Цэвэр, бохир ус	2,388,288.00	970,373.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,184,121.00	14,718,814.00
210401	Бичиг хэрэг	4,134,500.00	4,719,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,992,900.00	2,718,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	261,921.00	785,375.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	173,800.00	2,177,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,621,000.00	4,317,739.00
2105	Нормативт зардал	100,000.00	2,160,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	2,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,289,000.00	9,921,360.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,253,600.00	7,989,000.00
210602	Тавилга	20,000.00	1,932,360.00

2107	Томилолт, зочны зардал	12,351,654.00	900,000.00
210701	Гадаад албан томилолт	10,351,654.00	900,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,855,960.00	63,586,200.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,455,960.00	54,587,220.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	3,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000.00	999,400.00
210807	Газрын төлбөр	4,200,000.00	4,199,580.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,300,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,654,514.00	2,890,546.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,654,514.00	1,890,546.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,654,514.00	1,290,100.82
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/	00.00	600,446.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,885,400.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,885,400.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,885,400.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,885,400.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,885,400.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-7,885,400.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,258,814,021.00	2,546,117,750.34	280,524,417.59	4,085,456,188.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,411,624.60	7,411,624.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,258,814,021.00	2,546,117,750.34	287,936,042.19	4,092,867,813.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	647,600,000.00	00.00	00.00	647,600,000.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	335,093,817.38	335,093,817.38
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,546,117,750.34	623,029,859.57	5,075,561,630.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	9,709,113.60	9,709,113.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,906,414,021.00	2,546,117,750.34	632,738,973.17	5,085,270,744.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-9,709,113.60	00.00	-9,709,113.60
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-52,062,850.65	-52,062,850.65
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	580,676,122.52	5,023,498,780.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	341,456,400.00	340,166,299.18	1,290,100.82	99.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,456,400.00	340,166,299.18	1,290,100.82	99.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	340,456,400.00	339,166,299.18	1,290,100.82	99.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,140,900.00	218,956,231.00	184,669.00	99.9%
210101	Үндсэн цалин	160,324,600.00	178,784,262.00	(18,459,662.00)	111.5%
210102	Нэмэгдэл	49,467,400.00	30,192,253.00	19,275,147.00	61.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,348,900.00	9,979,716.00	(630,816.00)	106.7%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,392,600.00	27,392,600.00	-	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	18,627,000.00	17,278,438.00	1,348,562.00	92.8%
210202	Тэтгэмжийн даатгал	2,191,400.00	4,078,592.00	(1,887,192.00)	186.1%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,753,100.00	2,566,107.00	(813,007.00)	146.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	438,300.00	462,651.00	(24,351.00)	105.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,382,800.00	3,006,812.00	1,375,988.00	68.6%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,713,300.00	13,572,154.00	141,146.00	99.0%
210301	Гэрэл, цахилгаан	13,048,800.00	12,601,781.00	447,019.00	96.6%
210303	Цэвэр, бохир ус	664,500.00	970,373.00	(305,873.00)	146.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	15,053,500.00	14,099,114.00	954,386.00	93.7%
210401	Бичиг хэрэг	4,719,900.00	4,719,900.00	-	100.0%
210402	Тээвэр, шатахуун	2,718,400.00	2,718,400.00	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	796,200.00	785,375.00	10,825.00	98.6%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,177,400.00	2,177,400.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,641,600.00	3,698,039.00	943,561.00	79.7%
2105	Нормативт зардал	2,160,000.00	2,160,000.00	-	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,160,000.00	2,160,000.00	-	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,996,100.00	62,986,200.18	9,899.82	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,996,100.00	53,987,220.18	8,879.82	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,800,000.00	3,800,000.00	-	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	999,400.00	600.00	99.9%

210807	Газрын төлбөр	4,200,000.00	4,199,580.00	420.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	341,456,400.00	340,166,299.18	1,290,100.82	99.6%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	341,456,400.00	340,166,299.18	1,290,100.82	99.6%
131001	Улсын төсвөөс санхүүжих	341,456,400.00	340,166,299.18	1,290,100.82	99.6%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-	100.0%
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	-	100.0%
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	15	15	-	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		16,641,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		16,641,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		16,041,054.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,539,995.00
210104	Урамшуулал		3,539,995.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		459,999.00
210201	Тэтгэврийн даатгал		459,999.00
2104	Хангамж, бараа материалын зардал		619,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		619,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,921,360.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,989,000.00
210602	Тавилга		1,932,360.00
2107	Томилолт, зочны зардал		900,000.00
210701	Гадаад албан томилолт		900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		600,446.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		600,446.00
213305	Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлэг		600,446.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		16,641,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		16,641,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		16,641,500.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чойжин ламын сүм музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Отгонсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд зардлыг зөв ангилан тооцоолж, тохируулга бичилтийг үнэн зөв хийж сурах, нийгмийн даатгалын тайланг зөв шивэх, дотоод хяналтыг сайжруулж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Нансалмаа, аудитор Д.Мядагмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Чойжин ламын сүм музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Си Пи Ти Эй Аудит ХХК -д 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чойжин ламын сүм музейн эрхэм зорилго нь Музейд хадгалагдаж буй Монголын түүх, шашин, соёл, уран барилга, урлахуйн ухааны дахин давтагдашгүй үнэт бүтээлийг судлан сурталчилж, сэргээн баяжуулах, хадгалан, хамгаалж, хойч үеийнхэнд уламжлуулахад оршино.

Чойжин ламын сүм музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Музей, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа;
- Музейн нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, сургах, таашаал хүртээх зорилгоор хүн түүний орчинтой холбоотой бодит ба бодит бус байгаль, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, харилцан холбох байнгын үйл ажиллагаа бүхий ашгийн төлөө бус, олон нийтэд нээлттэй байгууллага байх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чойжин ламын сүм музейн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Чойжин ламын сүм музейн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгсөн байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 оны 3-р улирлын шилэн дансанд хийсэн дотоод аудитаар 5 сая төгрөгөөс дээш үнэ бүхий бараа, ажил үйлчилгээ худалдан авсан гүйлгээний тухайд гэрэл цахилгааны зардал, харуул хамгаалалтын зардлын 35,818.5 мянган төгрөгийн 18 удаагийн гүйлгээ гарсныг мэдээлээгүй, 2021 оны төсвийн төсөл, санхүү байдлын 2020 оны хагас жилийн тайлан болон төсвийн зарцуулалтын 9-р сарын тайланг огт мэдээлээгүй, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн зөрүүг тайлагнаагүй, тайлбарыг буруу талбарт оруулсан зэрэг зөрчил илэрсэн.

Чойжин ламын сүм музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3-р улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 158,067.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,580.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 422,563.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,225.6 мянган төгрөг болж өөрчлөгдсөн нь төлөвлөлтийн үеийн материаллагын түвшнийг 2020 оны 3-р улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чойжин ламын сүм музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,260.6 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	3,753.7	4,436.6	682.9
Урьдчилгаа	11,600.0	-	(11,600.0)
Бараа материал	45,045.2	52,550.8	7,505.6
Үндсэн хөрөнгө	5,015,162.7	4,968,313.6	(46,849.1)
Нийт хөрөнгө	5,075,561.6	5,025,301.0	(50,260.6)
Өр төлбөр	-	1,802.2	1,802.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,075,561.6	5,023,498.8	(52,062.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,075,561.6	5,025,301.0	(50,260.6)

Авлага дансны үлдэгдэл 4,436.6 мянган төгрөг болж 682.9 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдад илүү цалин бодож олгосоны авлага 466.6 мянга, татаас санхүүжилтийн авлага 600.4 мянган төгрөг, Адмон ХХК-д ном хэвлэлтэнд зориулж урьдчилан өгсөн 3,369.6 мянган төгрөг нийт 3,836.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд гэрэл цахилгааны оны эхний авлага 3,753.7 мянган төгрөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал данс 11,600.0 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд ном хэвлүүлэхээр гэрээ байгуулсан хэвлэлийн компаниас номоо хүлээж авснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 45,045.2 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд 38,778.1 мянган төгрөгийн худалдан авалт, 2,400.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, билетийн үнийн зөрүү 3.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 31,305.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, ТӨБЗГ-ын 2020 оны 774 тогтоолоор 2,370.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 52,550.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,968,313.6 мянган төгрөг болж 46,849.1 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь 7,752.4 мянган төгрөгийн худалдан авалт, 10,000.0 мянган төгрөгийн хувь хүнээс авсан хандивын хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2020 оны 774 тогтоолоор 20,314.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан хөрөнгө болон тайлант хугацааны элэгдлийн зардал 55,161.2 мянга, акталсан хөрөнгийн дансны хасалт 10,874.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,802.2 мянган төгрөг болж өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, хувь хүний орлогын албан татварын өглөгөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,023,498.8 мянган төгрөг болж 52,062.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Чойжин ламын сүм музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 535,873.7 мянган төгрөгөөр буюу 59 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 148,717.0 мянган төгрөгөөр буюу 26 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн цалин 17,892.6 мянга, нийгмийн даатгалын шимтгэл 5,872.8 мянга, хангамжийн материалын зардал 14,267.2 мянган төгрөгөөр тус тус өссөн, харин эд хогшил урсгал засварын зардал 203,067.4 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд “Өв эрдэнэ” төслөөр зам талбай, гэрэлтүүлгийн ажил хийгдсэнээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 499,924.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 499,924.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 158,468.0 мянган төгрөгөөр бууруулж 341,456.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 17 хөтөлбөрийн 54 арга хэмжээг санхүүжүүлэхээр 341,456.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 341,456.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 341,456.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 340,166.3 мянган төгрөгийг зарцуулж 1,290.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 340,166.3 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 184.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 141.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 954.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 9.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Энэ нь хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор төсөвлөсөн арга хэмжээ зохион байгуулагдаагүйтэй холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16,641.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 3,540.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 460.0 мянга, хангамжийн материалд 619.7 мянга, эд хогшил худалдан авахад 9,921.4 мянга, томилолтод 900.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажилд 600.0 мянга, нийт 16,041.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 600.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 139 мэдээллээс хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна.

Шилэн дансны хэрэгжилтийн судалгаагаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хувьд санхүүжилтийн 12 удаагийн 341.456.4 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлэхдээ сарын санхүүжилтийн гүйлгээг зөрүүлж өссөн дүнгээр 645,150.7 мянган төгрөгөөр мэдээлсэн байна. Таван сая төгрөгөөс дээш үнэ бүхий бараа ажил, үйлчилгээ худалдан авсан гүйлгээний тухайд гэрэл цахилгааны зардал, харуул хамгаалалтын зардлыг 1-9 сар хүртэл мэдээлээгүй байсан ба 10-р сараас эхлэн мэдээлж эхэлсэн байна. Мөн 2020 оны эхний хагас жилийн тайланг мэдээлээгүй, 2021 оны төсвийн төслийн мэдээлэлд 2021 оны батлагдсан төсвийг оруулж буруу мэдээлсэн зэрэг алдаа зөрчил илэрлээ.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,677.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 82 хувь биелэгдсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	2,677.2	3	2,196.1	2	481.1	18
Нийт дүн	5	2,677.2	3	2,196.1	2	481.1	18

/мянган.төг/

Зөвлөмжийн биелэлтийг шалгахад 2 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, орлогын төлөвлөгөөг төсөвт тусгах зөвлөмж хэрэгжээгүй байна. Байгууллагын эзэмшлийн тээврийн хэрэгсэл байхгүй боловч шатахууны зардалд 2,718.4 төгрөгийн төсөвтэй, шатахууныг зарцуулсан анхан шатны баримтын бүрдлийг нягтлахад “Жолоочийн тооцооны хуудас” хөтөлсөн нь тухайн сарын нэгдсэн дүнгээр бичсэн байна. Автомашин хэрэглэсэн тухай бүрд спидометрийн заалтыг үндэслээгүй ба зарцуулсан шатахууныг литр мөнгөн дүнгээр тооцож бодоогүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 136,854.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 103,248.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 33,606.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тус байгууллагын цалингийн тооцооллыг давтан хийхэд нийгмийн даатгалын тайлан, санхүү байдлын тайлан дахь цалингийн зардал нь зөрүүтэй тайлагнасан байхыг залруулснаас гадна нийт 466.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосныг залруулж авлага үүсгэсэн.
2. Санхүү байдлын тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг болох 1,466.8 мянган төгрөг, хүн амын орлогын албан татварын 335.4 мянган төгрөгийг өглөгийн бүртгэлд бүртгээгүйг тус тус залруулсан.
3. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн элэгдлийн тооцооллыг нягтлан шалгахад элэгдлийн зардал тооцоогүй байсан тул 55,161.2 мянган төгрөгийн элэгдлийг тооцоолон бүртгэж залруулсан.
4. Хандив тусламжаар авсан 10,000.0 мянган төгрөгийн бурхныг “Сүгдоржмаа хандив” гэж бүртгэснийг “Сүгдоржмаа таван хатны нэг” болгон өөрчилсөн.
5. Санхүү байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудын эхний үлдэгдэл нь өмнөх оны аудит хийгдсэн эцсийн үлдэгдэлтэй тохирохгүй байсныг залруулав.
6. Шилэн дансанд хийсэн хяналтаар 5 сая төгрөгөөс дээш үнэ бүхий бараа, ажил үйлчилгээ худалдан авсан гүйлгээний тухайд гэрэл цахилгааны зардал, харуул хамгаалалтын зардлын 35,818.5 мянган төгрөгийн гүйлгээ гарсныг мэдээлээгүй байсныг нөхөж мэдээлсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 33,606.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 2 албан шаардлага, шилэн дансны хэрэгжилтийн зөрчилд 1 албан шаардлага, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага тус тус 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тус байгууллагын нийт цалингийн дүн нийгмийн даатгалын тайлангаас зөрүүтэй тайлагнасан байна. 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл нийгмийн даатгалын тайлангаар 1,096.8 мянган төгрөг, санхүү байдлын тайлангаар 1,466.8 мянган төгрөг, НДШ өглөгийн зөрүү 370.0 мянган төгрөг болж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 төсвийг зохистой

удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалт, Эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 139 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.1 “Мэдээллийн үнэн зөв, бодитой иж бүрэн байх”, 4.1.3 “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх” заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,677.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 82 хувь биелэгдсэн байна.

Байгууллагын эзэмшлийн тээврийн хэрэгсэл байхгүй боловч шатахууны зардалд 2,718.4 төгрөгийн төсөвтэй, шатахууныг зарцуулсан анхан шатны баримтын бүрдлийг нягтлахад “Жолоочийн тооцооны хуудас” хөтөлсөн нь тухайн сарын нэгдсэн дүнгээр бичсэн байна. Автомашин хэрэглэсэн тухай бүрд спидометрийн заалтыг үндэслээгүй ба зарцуулсан шатахууныг литр мөнгөн дүнгээр тооцож бодоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Цахим баримтын ebarimt.mn системийн 70,769.9 мянган төгрөгийн и-баримтыг зарлагын баримтуудтай тулгахад 33,236.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ” гэсэн заалт, УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д “Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй” гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

1. Соёлын үнэт өв хөрөнгийг санхүүгийн тайланд багцаар нь түүх соёлын дурсгалт зүйл нэрийн дор нийт 1,001 дэсийн 6,384 ширхэг, 3,893,051.9 мянган төгрөгийн үзмэрийг нэг ширхгээр бүртгэсэн байна. Энэхүү 6,384 ширхэг үзмэр Соёлын өвийн мэдээллийн сангийн программ хангамжид дэлгэрэнгүйгээр бүртгэгдсэн гэх боловч тус байгууллагын санхүүгийн программд ашиглаж байгаа хөрөнгийн бүртгэлд дэлгэрэнгүй мэдээлэл алга байна. Энэ нь толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүгийн тайланд үзмэр тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэх шаардлагатай ба дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2. Тус байгууллагын газрын гэрчилгээ Чойжин ламын сүмийн нэр дээр байгаа боловч хойд талын 800 м.кв талбайг Чоно ХХК тохижуулан, ашиглаж байгаагаас гадна

тохижилтын төлбөрийг Чойжин лам музейгээс нэхэмжилсэн шүүхийн маргааны үргэлжлэл
байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн цалин, нэмэгдэл, хоол унааны олговрын зардлыг үр дүнгийн тайланд буруу ангилан, бүртгэл хөтөлсөн, Ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардлыг даатгалын сангуудад илүү дутуу ангилан бүртгэж бүртгэлийн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх”, БСШУС-ын 2017 оны А/40 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “3.4-д “Зардлын бүртгэлийн тусгай бодлого” хэсгийн зардлыг хүлээн зөвшөөрөх ба үнэлгээ гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Зардлыг зөв ангилан тооцоолж, тохируулга бичилтийг үнэн зөв хийж сурах, нийгмийн даатгалын тайланг зөв шивэх, дотоод хяналтыг сайжруулж, БСШУС-ын 2017 оны А/40 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Чойжин ламын сүм музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/76/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Чойжин ламын сүм музей		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус байгууллагын нийт цалингийн дүн нийгмийн даатгалын тайлангаас зөрүүтэй тайлагнасан байна. 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл нийгмийн даатгалын тайлангаар 1,096.8 мянган төгрөг, санхүү байдлын тайлангаар 1,466.8 мянган төгрөг, НДШ өглөгийн зөрүү 370.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	370.0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
2	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 127 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
3	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,677.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 82 хувь биелэгдсэн байна.	0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
4	Цахим баримтын ebarimt.mn системийн 70,769.9 мянган төгрөгийн и-баримтыг зарлагын баримтуудтай тулгахад 33,236.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн	33,236.0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
5	Үндсэн цалин, нэмэгдэл, хоол унааны олговрын зардлыг үр дүнгийн тайланд буруу ангилан, бүртгэл хөтөлсөн. Ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардлыг даатгалын сангуудад илүү дутуу ангилан бүртгэж бүртгэлийн алдаа гаргасан.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
ДҮН		33,606.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 202/А0170069

Улаанбаатар хот

САГ-2021/76/СТА-703

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойжин ламын сүм музейн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим баримтын ebarimt.mn системийн 70,769.9 /далан сая долоон зуун жаран есөн мянга есөн зуу/ мянган төгрөгийн и-баримтыг зарлагын баримтуудтай тулган үзэхэд 33,236.0 /гучин гурван сая хоёр зуун гучин зургаан/ мянган төгрөгийн худалдан авалтын и-баримт цахим системд бүртгэлгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. И-баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал Д.Отгонсүрэн, Ерөнхий нягтлан бодогч О.Хэрлэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Ч.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R Gazar195.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 201/НТ 0069
СНГ-2021/76/СТН-793

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойжин ламын сүм музейн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 139 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулан биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал Д.Отгонсүрэн, Ерөнхий нягтлан бодогч О.Хэрлэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 200/А0170069
СЯГ-2021/76/СЯГ-ТХБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойжин ламын сүм музейн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,677.2 /хоёр сая зургаан зуун далан долоон мянга хоёр зуу/ мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 82 хувьтай байгаа нь автомашин хэрэглэсэн тохиолдол бүрд спидометрийн заалтыг үндэслэн явсан км, зарцуулсан шатахууныг литр, мөнгөн дүнгээр үндэслэн тооцож бодоогүй байна.


Энэ нь Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тусгагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууныг нормоос хэтрүүлэн зарцуулсан дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал Д.Отгонсүрэн, Ерөнхий нягтлан бодогч О.Хэрлэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Ч.ЭНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 199/А0170069
САГ-2021/76/СТА-743

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойжин ламын сүм музейн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нийт цалингийн дүнг нийгмийн даатгалын тайлангаас зөрүүтэй тайлагнасан байна. Тухайлбал: 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл нийгмийн даатгалын тайлангаар 1,096.8 /нэг сая ерэн зургаан мянга найман зуу/ мянган төгрөг, санхүү байдлын тайлангаар 1,466.8 /нэг сая дөрвөн зуун жаран зургаан мянга найман зуу/ мянган төгрөг, НДШ-ийн өглөгийн зөрүү 370.0 /гурван зуун далан мянга/ мянган төгрөг болж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж, дээрх зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал Д.Отгонсүрэн, Ерөнхий нягтлан бодогч О.Хэрлэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.Хангалваа

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Ч.ЭНХЧИМЭГ

